



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/108/НА-СТА-ТШЗ

Баянхонгор 2022 он	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Д.Цэцэгмаа Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaa_1961@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	--

Агуулга

1.Аудитын гэрчилгээ /эх хувь/	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч, зөрчдийг арилгах 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна.Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.10.01-ний 121 тоот албан бичгээр ирүүлсэн байна.	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЖАРГАЛАНТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ТҮМЭНЖАРГАЛ ТАНАА

**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.24 № 2/94

танай _____ -ны № _____ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Жаргалант сумын Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН		СТ-1А	
		/Төгрөгөөр/	
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>54.743.252.47</u>	<u>441.101.828.78</u>
33	АВЛАГА	00.00	341.521.646.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	241.646.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	341.280.000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	54.743.252.47	99.580.182.78
351	Түүхий эд материал	10.837.320.65	49.273.510.96
35110	Тусгай зориулалттай материал	6.859.360.36	19.344.702.36
35130	Эм боох материал	3.977.960.29	29.928.808.60
354	Хангамжийн материал	43.905.931.82	50.306.671.82
35410	Бичиг хэргийн материал	1.635.150.00	1.368.800.00
35420	Аж ахуйн материал	35.662.197.76	40.904.889.76
35430	Сэлбэг хэрэгсэл	555.000.00	2.250.000.00
35440	Түлш, шатах тослох материал	1.190.600.06	00.06
35450	Барилгын засварын материал	3.811.700.00	3.811.700.00
35460	Хүнсний материал	953.284.00	1.873.282.00
35470	Бусад хангамжийн материал	98.000.00	98.000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>704.914.850.06</u>	<u>702.210.307.01</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	704.914.850.06	702.210.307.01
392	Биет хөрөнгө	691.171.141.69	688.604.098.60
39201	Барилга, байгууламж, орон сууц	828.338.254.00	828.338.254.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	-236.502.961.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	34.835.000.00	3.440.000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-19.911.458.34	-3.054.333.49
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	273.080.479.30	321.693.876.96
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	-235.409.637.04
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25.987.161.00	28.187.161.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16.247.898.79	-19.384.946.20
39217	Ном	871.685.00	1.296.685.00
393	Биет бус хөрөнгө	13.743.708.37	13.606.208.41
39301	Програм хангамж	1.055.000.00	1.055.000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-617.291.63	-754.791.59
39303	Бусад биет бус хөрөнгө	13.306.000.00	13.306.000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>759.658.102.53</u>	<u>1.143.312.135.79</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>44.849.895.40</u>

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
		00.00	44.849.895.40
413	Өглөг	00.00	44.849.895.40
4136	Бусад өглөг	00.00	44.849.895.40
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	43.389.895.40
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	1.460.000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	759.658.102.53	1.098.462.240.39
51	Засгийн газрын хувь оролцоо	759.658.102.53	1.098.462.240.39
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	605.279.606.00	605.279.606.00
51101	Өмч: - төрийн	605.279.606.00	605.279.606.00
512	Хуримтлагдсан үр дүн	-	-
51210	Өмнөх үеийн үр дүн	203.983.111.64	-203.983.111.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	338.804.137.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	358.361.608.17	358.361.608.17
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	759.658.102.53	1.143.312.135.79

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	623.838.426.65	1.199.278.239.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70.579.838.65	76.731.501.86
120	Нийтлэг татварын бус орлого	70.579.838.65	76.731.501.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70.579.838.65	27.388.104.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	610.000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	69.969.838.65	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого ҮХ		49,343,397.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого БМ		27,388,104.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	553.258.588.00	1.122.543.738.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	512.311.700.00	469.908.200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	512.311.700.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	469.908.200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12.130.666.00	587.152.872.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11.822.766.00	74.767.872.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	307.900.00	00.00
131107	нэмэлт		512.385.000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	40.100.800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	40.100.800.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28.816.222.00	25.384.866.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28.816.222.00	25.384.866.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	590.781.165.20	850.562.435.28
21	УРСГАЛ ЗАРДАЛ	590.781.165.20	850.562.435.28
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	585.205.717.47	814.983.181.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359.922.176.27	369.611.512.00
210101	Үндсэн цалин	216.067.000.00	219.828.636.00
210102	Нэмэгдэл	105.283.240.00	110.795.376.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6.581.448.63	5.525.000.00
210104	Урамшуулал	31.990.487.64	33.462.500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44.855.586.00	48.529.750.00
210201	Тэтгэврийн даатгал	30.694.100.00	35.535.297.00
210202	Тэтгэмжийн даатгал	3.416.686.00	3.208.397.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.865.300.00	2.783.900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	716.300.00	695.950.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7.163.200.00	6.306.206.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38.557.576.00	41.451.400.00
210301	Гэрэл, цахилгаан	3.583.176.00	4.372.800.00
210302	Түлш, халаалт	34.896.400.00	36.778.600.00
210303	Цэвэр, бохир ус	78.000.00	300.000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24.401.345.24	57.782.607.00
210401	Бичиг хэрэг	3.617.020.00	3.525.850.00
210402	Тээвэр, шатахуун	15.288.584.00	23.244.600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	560.000.00	2.015.800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70.101.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4.865.640.24	28.996.357.00
2105	Нормативт зардал	52.183.587.00	144.296.064.29
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	41.602.875.00	120.524.532.29
210502	Хоол, хүнс	10.580.712.00	23.771.532.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9.334.200.00	2.221.000.00
210604	Урсгал засвар	9.334.200.00	2.221.000.00
2107	Томилолт, зочны зардал	1.505.000.00	727.000.00
210702	Дотоод албан томилолт	1.505.000.00	727.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.392.240.00	102.256.273.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	602.300.00	101.806.273.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	450.000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119.250.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104.360.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33.000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1.466.800.00	00.00
210807	Газрын төлбөр	66.530.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	52.054.006.96	48.107.574.99
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2.611.900.00	4.076.301.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49.442.106.96	44.031.273.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5.575.447.73	35.579.254.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5.101.366.00	35.578.872.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4.443.366.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	35.578.872.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	658.000.00	00.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	474.081.73	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	474.081.73	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	82.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	00.00	82.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	300.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33.057.261.45	348.715.804.58
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	9.911.666.72
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	9.911.666.72
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-9.911.666.72
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33.057.261.45	338.804.137.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	553.868.588.00	781.266.738.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	610.000.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	610.000.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	610.000.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	610.000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	553.258.588.00	781.266.738.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	512.311.700.00	469.908.200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	512.311.700.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	469.908.200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12.130.666.00	245.872.872.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11.822.766.00	74.767.872.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	307.900.00	00.00
131107	нэмэлт		171.105.000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	40.100.800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	40.100.800.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	28.816.222.00	25.384.866.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28.816.222.00	25.384.866.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	550.527.588.00	779.371.738.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	550.527.588.00	779.371.738.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	544.770.140.27	743.792.484.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	359.922.176.27	369.386.200.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210101	Үндсэн цалин	216.067.000.00	220.191.100.00
210102	Нэмэгдэл	105.283.200.00	110.207.600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6.581.488.63	5.525.000.00
210104	Урамшуулал	31.990.487.64	33.462.500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44.855.586.00	48.996.708.00
210201	Тэтгэврийн даатгал	30.694.100.00	34.631.937.00
210202	Тэтгэмжийн даатгал	3.416.686.00	3.479.821.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.865.300.00	2.783.900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	716.300.00	695.950.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7.163.200.00	7.405.100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38.255.176.00	39.600.800.00
210301	Гэрэл, цахилгаан	3.583.176.00	4.372.800.00
210302	Түлш, халаалт	34.594.000.00	34.928.000.00
210303	Цэвэр, бохир ус	78.000.00	300.000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	22.475.021.00	25.833.207.00
210401	Бичиг хэрэг	966.720.00	1.200.000.00
210402	Тээвэр, шатахуун	15.287.000.00	19.667.500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	360.000.00	2.015.800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2.211.301.00	2.000.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3.650.000.00	949.907.00
2105	Нормативт зардал	59.081.531.00	36.926.900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	44.274.731.00	26.121.900.00
210502	Хоол, хүнс	9.476.800.00	8.300.000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5.330.000.00	2.505.000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9.589.200.00	2.000.000.00
210604	Урсгал засвар	9.589.200.00	2.000.000.00
2107	Томилолт, зочны зардал	1.505.000.00	412.000.00
210702	Дотоод албан томилолт	1.505.000.00	412.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3.603.140.00	209.243.918.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	822.300.00	208.793.918.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	450.000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119.250.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80.000.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33.000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1.666.800.00	00.00
210807	Газрын төлбөр	66.530.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	98.960.00	00.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	716.300.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5.483.310.00	11.392.751.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5.483.310.00	11.392.751.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5.757.447.73	35.579.254.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5.283.366.00	35.578.872.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4.743.366.00	35.578.872.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	540.000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	474.081.73	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	474.081.73	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	82.00
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	00.00	82.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	300.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	300.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>3.341.000.00</u>	<u>1.895.000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>3.341.000.00</u>	<u>1.895.000.00</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>3.341.000.00</u>	<u>1.895.000.00</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	3.341.000.00	1.895.000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3.341.000.00	1.895.000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-3.341.000.00</u>	<u>-1.895.000.00</u>
7	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	<u>00.00</u>	<u>00.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605.279.606.00	358.361.608.17	-203.983.111.64	00.00	759.658.102.53
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	605.279.606.00	358.361.608.17	-203.983.111.64	00.00	759.658.102.53
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	605.279.606.00	358.361.608.17	-203.983.111.64	00.00	759.658.102.53
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	338.804.137.86	00.00	338.804.137.86
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605.279.606.00	358.361.608.17	134.821.026.22	00.00	1.098.462.240.39

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	538.938.000.00	535.393.566.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	538.938.000.00	535.393.566.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	538.938.000.00	535.393.566.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	370.253.500.00	369.386.200.00
210101	Үндсэн цалин	220.346.400.00	220.191.100.00
210102	Нэмэгдэл	110.207.600.00	110.207.600.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6.237.000.00	5.525.000.00
210104	Урамшуулал	33.462.500.00	33.462.500.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49.984.100.00	48.996.708.00
210201	Тэтгэврийн даатгал	35.174.000.00	34.631.937.00
210202	Тэтгэмжийн даатгал	3.702.500.00	3.479.821.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2.962.000.00	2.783.900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	740.500.00	695.950.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7.405.100.00	7.405.100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39.705.500.00	39.600.800.00
210301	Гэрэл, цахилгаан	4.372.800.00	4.372.800.00
210302	Түлш, халаалт	34.932.700.00	34.928.000.00
210303	Цэвэр, бохир ус	400.000.00	300.000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26.133.500.00	26.133.207.00
210401	Бичиг хэрэг	1.200.000.00	1.200.000.00
210402	Тээвэр, шатахуун	19.667.500.00	19.667.500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2.016.000.00	2.015.800.00
210404	Ном, хэвлэл	300.000.00	300.000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2.000.000.00	2.000.000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	950.000.00	949.907.00
2105	Нормативт зардал	36.931.900.00	36.926.900.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	26.121.900.00	26.121.900.00
210502	Хоол, хүнс	8.300.000.00	8.300.000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2.510.000.00	2.505.000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2.000.000.00	2.000.000.00
210604	Урсгал засвар	2.000.000.00	2.000.000.00
2107	Томилолт, зочны зардал	412.800.00	412.000.00
210702	Дотоод албан томилолт	412.800.00	412.000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	450.000.00	450.000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450.000.00	450.000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13066700.00	11487751.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13.066.700.00	11.487.751.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	538.938.000.00	535.393.866.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	469.908.200.00	469.908.200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	469.908.200.00	469.908.200.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	40.205.500.00	40.100.800.00
132001	Орон нутгийн төсвөөс	40.205.500.00	40.100.800.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28.824.300.00	25.384.866.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28.824.300.00	25.384.866.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25	29
620001	Удирдах ажилтан	01	01

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

620002	Гүйцэтгэх ажилтан	19	20
620003	Үйлчлэх ажилтан	05	08
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	00	363
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	00	363
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25	29
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20	21
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05	08

2.6.Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

НТ-2

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,130,666.00	245,872,872.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,130,666.00	245,872,872.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,387,300.00	00.00
210101	Үндсэн цалин	2,250,000.00	00.00
2105	Нормативт зардал	2,250,000.00	00.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,137,300.00	00.00
210502	Хоол, хүнс	5,000,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	137,300.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		210,293,918.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	35578872.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		35,578,872.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	4,743,366.00	35,578,872.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		82.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,130,666.00	245872872.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,130,666.00	245,872,872.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	11,822,766.00	74,767,872.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	307,900.00	00.00

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

131107	нэмэлт орлого		171,105,000.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газартай хийсэн гэрээний үндсэн дээр “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, чанарын хяналтыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд тайланд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 09 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Санхүүгийн тайлант хугацаанд Эрүүл мэндийн төвийн эрхлэгч Г.Алтантуяа нэгдүгээр гарын үсгийг, нягтлан бодогч Д.Амартүвшин нар хоёрдугаар гарын үсгийг тус тус зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулсан байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жаргалант сумын ЭМТ нь Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг жигд сайжруулж, хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, эмчилгээ оношилгооны орчин үеийн аргыг нэвтрүүлснээр хүн амын эрүүл мэндийг сайжруулах, хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй үзүүлэх зорилтыг дэвшүүлэн ажилласан байна

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2021 оны 12 дугаар сарын 27-ны

өдрийн 38 тоот тушаалаар батлагдсан салбарын хэмжээнд мөрдөх байгууллагын өөрийн онцлогт нийцүүлэн боловсруулж холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг ашиглаж байна.

Тус байгууллага нь дотоод аудитын албан байхгүй бөгөөд дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт аудитын алба нь хэрэгжүүлдэг ба Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатны материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 590,781.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,861.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 6,646.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 12,758.4 мянган төгрөг, гүйцэтгэлийн материаллаг байдал 9,568.8 мянган төгрөг буюу 2,922.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь Ковид -19 цар тахалтай холбоотой нэмэлт санхүүжилтийн дансаар ЭМД-ын санхүүжилтийн 245,872.8 мянган төгрөгийн орлого төвлөрч зарцуулагдсан, ЭМДС-гийн дутуу санхүүжилтийн 341,280.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланг орлогоор хүлээн зөвшөөрч авлага үүссэнтэй холбоотой тул өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 1,143,312.1 мянган төгрөг болж өмнөх оноос 383,654.0 мянган төгрөгөөр буюу 33,5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, тусгай зориулалтын материал, эм, ороох боох материал, аж ахуйн материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Жаргалант сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	54,743.3	441,101.8	386,358.6
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	341,521.6	341,521.6
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	54,743.3	99,580.2	44,836.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	704,914.9	702,210.3	(2,704.5)
Үндсэн хөрөнгө	1,177,473.6	1,197,317.0	19,843.4
Хуримтлагдсан элэгдэл	(472,558.7)	(495,106.7)	(22,547.9)
Нийт хөрөнгө	759,658.1	1,143,312.1	383,654.0
Өр төлбөр	-	44,849.9	44,849.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	759,658.1	1,098,462.2	338,804.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	759,658.1	1,143,312.1	383,654.0

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлангаас авав.

Бараа материалын дансны үлдэгдэл 99,580.2 мянган төгрөг болж 44,836.9 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 12,485.4 мянган төгрөгөөр, эм боох материалын дансны үлдэгдэл 25,950.9 мянган төгрөг, аж ахуйн материал 5,242.7 мянган төгрөг болж тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлж байна. Энэ нь Ковид -19 цар тахалтай холбоотой хамгаалах хэрэгсэл, эмийн нөөцийг нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 341,521.6 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 өвчлөлийн ЭМД-ын сангаас орох санхүүжилт тайлант ондоо ороогүй ба авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,197,317.0 мянган төгрөг болж 19,843.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 1,500.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 395.0 мянган төгрөгөөр ном худалдан авч, 32,563.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө ЭМЯ-аас үнэ төлбөргүй нийлүүлэгдсэн, ОНХС-гаас 8,900.0 мянган төгрөгийн биохимийн аппарат, 7,880.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг иргэдийн хандиваар хүлээн авч, Аймгийн ИТХ тэргүүлэгчдийн 2021.12.14-ний 137 тоот тогтоол, 2021.09.17-ний өдрийн 102 тоот тогтоолоор 31,395.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл акталснаас шалтгаалжээ.

Өглөг дансны үлдэгдэл 44,849.9 мянган төгрөг байгаа эь ЭМД-ын санхүүжилт бүрэн ороогүйтэй холбоотой ба үүнээс Түмэн наст фарм ХХК-д эмийн 29,809.3 мянга, аймгийн ЭМГ-т эмийн 9,724.6 мянга, Эрдэнэ тлгой ирээдүй ХХК-д материалын 2,236.0 мянга, Олз баялаг ХХК-д хүнсний материалын 1,585.8 мянган төгрөгийн өртэй ба өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,098,462.2 мянган төгрөг болж 338,804.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн системийн байгууллагууд төсвийн төлөвлөлтийг хийхдээ цалингийн зардал, тогтмол зардлын төсвийг төлөвлөж, бусад суурь үзүүлэлтийг ЭМГ-т хүргүүлдэг ба системийн дээд байгууллага нь нэг иргэнээр тооцсон хувьсах зардлын нормативыг баримтлан тухайн сумын хүн амын тоотой харьцуулж төсвийг төлөвлөдөг ба тайлант онд 538,938.0 мянган төгрөгийг зарцуулах төсөв батлагдсан байна. Батлагдсан төсвийн нийт дүнд өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 538,938.0 мянган төгрөгийн төсөв баталснаас улсын төсвөөс 469,908.2 мянга, орон нутгийн төсвөөс 40,205.5 мянга, ЭМДС-гаас 28,824.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 469,908.2 мянга, орон нутгийн төсвөөс 40,100.8 мянга, ЭМД-аас 25,384.6 мянга, нийт 535,393.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 535,393.6 мянган төгрөгийг зарцуулсан нь орон нутгийн төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 3439.4 мянган төгрөгөөр, ЭМД-аас авах санхүүжилтийг 104.7 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 535,393.5 мянган төгрөг буюу 99,3 хувьтай байгаа нь ЭМД сангаас санхүүжих санхүүжилт 3439.4 мянган төгрөг дутуу байгаагаас шалтгаалжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар 245,872.8 мянган төгрөг төвлөрсний 171,105.0 мянган төгрөг нь Ковид-19 цар тахлын эмчилгээний төлбөрөөс орсон орлого байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа ЭМЯ, улсын болон аймгийн онцгой комиссоос өгсөн шийдвэр, чиглэлийн дагуу тусгай горимоор ажилласан.

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Ковид-19 өвчлөлийг эмчлэх болон түүнээс урьдчилан сэргийлэх, Ковид-19-ын халдварын дархлаажуулалтын үйл явц зэрэг онцлог үйл явцууд гарснаас гадна Ковид-19 өвчлөл ихэссэнтэй холбоотойгоор нийт 65 ортой халдварын эмнэлэг нэмж дэлгэсэн.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 38 арга хэмжээ тусгагдсанаас хэрэгжилт 95.7%-тай гэж тайлагнагдсан.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 850,562.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 259,781.3 мянган төгрөгөөр буюу 43,9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин хөлс, НДШ-ийн зардал 13,363.4 мянга, норматив зардал 92,112.5 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардал 99,864.1 мянган төгрөгөөр өссөн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны мэдээллийн сайтад оруулбал зохих 151 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, мэдээлбэл зохих 149 мэдээллээс тухай бүр мэдээлэх үнийн дүнгүй Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг 2 удаа хугацаа хоцроож мэдээлснээс бусад мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаа нь тусгай чиг үүрэг бүхий байгууллага тул дээрх тогтоолд хамаарахгүй болно.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 28,268.4 мянган төгрөгийн шатах тослох материалыг харьцуулалтын аргаар худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулсан байна. Тайлант онд худалдан авах эмийн тендерийг аймгийн ЭМГ нэгдсэн журмаар зохион байгуулсан байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авч, зөрчдийг арилгах 2 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2021.10.01-ний 121 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд ЭМД-аас авах санхүүжилтийн 341,280.0 мянган төгрөгийн авлага, 44,849.9 мянган төгрөгийн өглөг үүссэн ба цаашид өглөг авлагын тооцоог тухайн онд нь багтаан шийдвэрлэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

_____оОо_____